

“Хай Би Ойл” ХК-ийн 2021 оны жилийн

үйл ажиллагааны тайлан

Нэр: “Хай Би Ойл” ХК

Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ 110 тоот

Утас: (+976) - 8811 9740 9990 4034

Улсын бүртгэлийн дугаар: 9010001063

Регистрын дугаар: 2615134

Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах тусгай зөвшөөрлийн бүртгэлийн дугаар: 000009

Үйл ажиллагааны чиглэл: Техникийн хаягдал тос дахин боловсруулах

Үнэт цаасны тоо ширхэг: 52 118 954 ширхэг

Үйлдвэрлэл, борлуулалтын тухайд:

Өмнөх оны түүхий эдийн тосны үлдэгдэл нөөц 480,873 литр, боловсруулсан тосны нөөц /Мазут/ 137,217 литр байсан ба 2021 он гарснаас хойш тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК нь нийт 487,920л техникийн ашигласан хаягдал тосыг байгууллагуудтай хийсэн гэрээний дагуу цуглуулсан байна. Үүнээс 281,809л мазут боловсруулан авч 3 аж ахуйн нэгжид 200,181 тонн мазутыг 135,007,000₮ / НӨАТ орсон үнэ/төгрөгөөр борлуулсан. Дээрх тоон үзүүлэлтүүдийн задаргааг харуулбал:

Түүхий эд материал:

Нэр	Нэгж	2020 оны үлдэгдэл	2021 оны бүтэн жилээр
Түүхий эд буюу ажилласан масло	литр	480,873	487,920
Нийт	литр	968,793	

Борлуулалт: Мазут

№	Худалдан авсан байгууллагын нэр	Хэмжээ	НӨАТ орсон үнэ /төгрөг/
			Нийт үнэ
1	“Наранбулаг Хан” ХХК	94,680тн	71,862,000₮
2	“Арж Роуд” ХХК	1тн	900,000₮
3	“Блүүм Ойл”ХХК	105,500тн	62,245,000₮
Бүгд дүн		200,181тн	135,007,000₮

Гэрээ хэлцэлүүд болон томоохон худалдан авагчид:

2021 оны тайлант хугацаанд гэрээ ажил үйлчилгээ үзүүлэх 1 гэрээ, худалдах ба худалдан авахтай холбогдолтой 7 гэрээнүүд тус бүр байгуулсан байна

2021 онд хийгдсэн гэрээнүүдийг жагсаавал:

№	Гэрээ байгуулсан компани	Гэрээний агуулга	Эхлэх	Дуусах	Гэрээний үнэ
Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ					
1	СХД-ийн Татвар,Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв	ХХҮХураамж, тээвэрлэх гэрээ	2021/03/31	2021/12/31	Сар бүр 20 000
Худалдах, худалдан авах гэрээ					
1	“Наранбулаг хан”ХХК	Мазут худалдах	2021/04/01	2022/04/01	280 000 000₮
2	“Эко Асфальт”ХХК	Мазут худалдах	2021/05/11	2022/05/11	270 000 000₮
3	“Хэт Моторс”ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/30	2022/04/01	Газар дээрээс нь очиж авах
4	“Хан Богд Вейст Менежмент Центр” ХХК /Оюу Толгой” ХХК/	Хамтын ажиллагааны гэрээ /Ажилласан масло нийлүүлэх/	2021/04/01	2021/10/01	Газар дээрээс нь очиж авах
5	“Петронано” ХХК	Техникийн хаягдал тос авах	2020/11/06	2021/12/31	Газар дээрээс нь очиж авах
6	“СТЕП ГОЛД” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/11	2021/12/31	Газар дээрээс нь очиж авах
7	“ПЕТРОТРАКТ” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/30	2022/04/01	Газар дээрээс нь очиж авах
8	“Цайртминерал” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/01	2021/12/30	Газар дээрээс нь очиж авах
9	“Ар Эс И” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/11	2021/12/30	Газар дээрээс нь очиж авах
10	“МСМ” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/01/01	2022/12/31	Газар дээрээс нь очиж авах
11	“АвтоХаб” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/01	2022/03/31	Газар дээрээс нь очиж авах
12	“Автоланд” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/01	2022/03/31	Газар дээрээс нь очиж авах
13	“Делта Авто сервис” ХХК	Техникийн хаягдал тос авах	2021/03/01	2022/03/31	Газар дээрээс нь очиж авах

Тайлант хугацаанд үйлдвэрлэлт борлуулалтаас гадна хийгдсэн ажлууд:

- Манай байгууллага болон бусад харилцагч байгууллагууд нь /Ковид 19/ цар тахлын улмаас тависан хорио цээр болон бусад эдийн засгийн асуудлуудаас үүдэн явуулж байгаа үйл ажиллагаанууд жигд биш удаашралтай зогсонги байдалтай байсан.
- “Аюултай хог хаягдал” цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах үйлдвэрлэл эрхлэхэд Байгаль Орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах үүднээс Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр гаргаж, өмнөх оны төлөвлөгөөний биелэлтийг тайлагнадаг ба үүний дагуу бид 2020 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөөний Биелэлтийн тайлангаа хянуулж, 2021 оны Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө боловсруулан БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газраар баталгаажуулсан.

1. Боловсруулсан бүтээгдэхүүн болон М-100 маркын мазутыг Газрын тос, Газрын тосны бүтээгдэхүүний итгэмжлэгдсэн лаборатори “Амбер”ХХК-иар жилд 2-3 удаа шинжлүүлж баталгаажуулсан.



Зураг 1. Мазутын дээж шинжилгээ

2. Үйлдвэрийн дэргэдэх зөөврийн оффист засвар үйлчилгээ хийж 2 өрөөг нэгтгэн хуучин хулдаасан шалыг нь паркетан шалаар сольж засав.



Зураг 2. Оффисын өрөөний засвар үйлчилгээ

2. Ажилчидын унаа машин (Stagex) болон бусад тээврийн хэрэгсэл автомашинуудад ээлжит урсгал засвар үйлчилгээнүүдийг хийж, тээврийн хэрэгслийн даатгал, татвар, улсын үзлэг, оношилгоонд бүрэн хамруулсан.





3.



Зураг 3. Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ

4. Нийслэл хот дотроо үйл ажиллагаа явуулдаг авто засварын газруудаас “Техникийн ашигласан хаягдал тос” тээвэрлэдэг зориулалтын 2 автомашинуудад хот дотор явах ЕС зөвшөөрлийн сунгалтыг хийлгэж хагас жилээр түр зөвшөөрлөө авсан.




Зураг 4. Авто мишины түр зөвшөөрөл

5. Агаарт үүсэх тоосжилтоос сэргийлэх мөн хөрсийг хамгаалах чиглэлийн дагуу хашааны дотор талбайн хог ачих цэгийн суурь, ажилчдын байрны талбай, үйлдвэрийн барилгын урд хэсэг, газар доорхи 3 агуулах савны тос буулгах талбайн хэсэгүүдийг бетондон, бохирдсон хэсгийн хорыг саармагжуулах ажил хийгдсэн.



Зураг 5. Талбай бетондож буй ажлын явц

6. 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах бэлтгэл ажлын нэг хэсэг буюу цахилгаан хангамжийн гол хэсэг болох КТП 630 трансформаторт мэргэжлийн хүмүүсээр тос нэмүүлж аюулгүй ажиллагааг хангав.



Зураг 6. Трансформаторын засвар үйлчилгээ

7. Ажилчдын угаалгын өрөөнд угаалтуур, хувцас угаах угаалгын машин болон усанд орох шүршүүрийг суурьлуулж тохижилтын ажлыг хийж гүйцэтгэг байна.




Зураг 7. Ажилчдын угаалгын өрөө

8. Хаягдал тос хүлээж авах цэгийн хөрсийг хамгаалах үүднээс талбайг бетондох тул энэ ажилтай холбогдуулан агуулахын зориулалттай блокон барилгыг шилжүүлэн барьсан.




Зураг 8. Блокон барилгыг шилжүүлэн барьж буй ажлын явц

9. Үйлдвэрийнхаяг байршиллын тодорхойлолтыг шинээр хийлгэсэн бөгөөд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын захирамжаар 2008 онд байгуулсан газар эзэмших гэрээг шинэчилэн байгуулж , газар эзэмших гэрчилгээг шинэчилж авсан.



Зураг 9. Барилгын хаяг байршиллын тодорхойлолт



Зураг 10. Газар эзэмших гэрчилгээ болон кадастар

10. “Монголын Хог Хаягдлыг Дахин Боловсруулах Үндэсний Холбоо”-ны энгийн болон аюултай хог хаягдлын мэргэжлийн холбооны нэгдсэн сургалтанд компанийн гүйцэтгэх захирал ажилтны хамт хамрагдаж сертификат авсан. Сертификатыг доор харуулав.



Зураг 11. Монголын Хог Хаягдалын сертификат

11. Байгаль Орчины Яамны харьяа төв лаборторт жил бүр хаягдал усны шинжилгээ өгч хаягдал ус хаях зөвшөөрөл 1 жилийн хугацаатай авсан.



Зураг 12. Хаягдал усны зөвшөөрөл

12. 2021 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

2021 онд нийт 133,363.0 төгрөгийн борлуулалтын орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 82,967.2 төгрөг, ерөнхий удирдлагын зардал 301,719.3 төгрөг, бусад зардалд 7,483.1 төгрөг болсон байна. Үүнээс:

1. Цалингийн зардал	127,455.3₮
2. НДШ-д	15,312.6₮
3. Ашиглалт болон урсгал засвар үйлчилгээнд	8,242.1₮
4. Албан татварт	7,294.2₮
5. Түлш шатахуун тээвэрт	20,072.3₮
6. Элэгдэл, хорогдлын зардал	100,927.2₮
7. Шуудан холбоо, бичиг хэрэг, мэргэжлийн үйлчилгээнд	22,415.6₮
8. Бусад зардалд	7,483.1₮

- Өмнөх оны авлага 2,375,898.1 төгрөг, дансны өглөг 159,040.7 төгрөг байна.

13. 2021.04.26 "Хай Би Ойл" ХК-ийн ХЭХ-ын хурлын талаар:

1) 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Даваа гаригийн 10:00 цагт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Zoom <https://zoom.us/> программыг ашиглан /Meeting ID: 991 580 0570 Passcode: 88035811/ зарлан хуралдуулж дараах асуудлуудыг шийдвэрлэсэн.

- Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
- Компанийн дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;

Дээрх хуралдааны тогтоол шийдвэрүүдийг Монголын Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн бирж, түүний вэб хуудаснуудад тухай бүр өгч хууль дүрэм, журмын дагуу байршуулан ажилласан.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

Компани нь нийт 52'118'954 ширхэг хувьцаатай ба 379 хувьцаа эзэмшигчидтэй байна. Үүнээс нийт хувьцааны 5% буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Нийт хувьцааны	
		Тоо ширхэг	Хувь
1	"БиДиСЕК" ХК	8 252 197	15.83%
2	"Кибер циркл" ХХК	16 609 841	31.87%
3	"Монгол алтан минт" ХХК	4 167 934	8.00%
4	"Нью альфа" ХХК	17'327'908	33.25%
Дүн			88.95%

/ ҮЦТХТ-өөс 2021.04.06-ний өдрөөр тасалбар болгон авсан мэдээ. /

Удирдлагын талаархи мэдээлэл:

2021.04.26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Пүрэвбаатар, Б.Лхагвадорж, Т.Батгэрэл, С.Одгэрэл, Р.Оюунбат, Б.Дөлгөөнтамир нар, хараат бус гишүүдээр А.Харцага, Т.Тамир, Ж.Болорцэцэг нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Пүрэвбаатар, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр

Н.Батнайрамдал нар сонгогдож ажиллаж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

ТУЗ-ийн хурлын талаар:

Тайлант хугацаанд “Хай Би Ойл” ХК-ийн ТУЗ нь 6 удаа санал асуулгаар хуралдсан байна. Үүнд:

1. 2021 оны 02 сарын 08-ны өдөр ТУЗ-ийн нийт гишүүдэд саналын хуудас хүргүүлж
 - А. “Гэрэлтхөхийн тэнцвэр аудит” ХХК-аар 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлгэх тухай,
 - Б. ТУЗ-ийн гишүүн Э.Эрдэмбилэг чөлөөлөгдөх хүсэлт гаргасаны дагуу ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, Б.Батхуягийг түр гишүүнээр томилох тухай,
 - В. 2020 оны үйл ажиллагаанаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлах эсэх, асуудлуудыг хэлэлцээд “Гэрэлтхөхийн тэнцвэр аудит” ХХК-аар аудит хийлгэх, гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгаж, мөн ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилгийг чөлөөлж, Б.Батхуягийг түр гишүүнээр томилох, 2020 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг тус тус гаргасан.
2. 2021 оны 03 сарын 17-ны өдөр саналын хуудсаар “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай асуудлыг хэлэлцэж Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг 2021 оны 04 сарын 26-ны өдөр хуралдуулхаар шийдвэрлэсэн.
3. 2021 оны 05 сарын 17-ний өдөр саналын хуудсаар хуралдаж, 2021 оны 04 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралаар томилогдсон ТУЗ-ын гишүүдээс ТУЗ-ын дарга, ТУЗ дэргэдэх хороодын бүрэлдэхүүнүүдийг болон ТУЗ-нарийн бичгийн даргыг тус тус томилж шийдвэрлэсэн болно.
4. 2021 оны 05 сарын 17-ний өдөр саналын хуудсаар хуралдаж Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 1638 тоот Шүүгчийн захирамжийг биелүүлүүлэх 435 дугаар бүхий гүйцэтгэх хуудастай шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд төлбөр авагч “Хай Би Ойл” ХК-ийг төлөөлөн Дархан-Уул аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай гэрээ байгуулах, хүсэлт, гомдол гаргах зэрэг төлбөр авагчийн эдлэх бүрэн эрхийг гүйцэтгэх захирал Ш.Амар-Отгонд олгож шийдвэрлэсэн.
5. 2021 оны 07 сарын 19-ний өдөр саналын хуудсаар хуралдаж ТУЗ-ийн гишүүн Бүрэнмэндийн Лхагвадорж чөлөөлөгдөх хүсэлт гаргасаны дагуу ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, түр гишүүнээр Нямжаргалын Гүнжидмааг томилж шийдвэрлэсэн.
6. 2021 оны 09 сарын 28-ний өдөр саналын хуудсаар хуралдаж Шарын гол ХК-аас авах 2 282 879 519.32 төгрөгийн авлагтаа 2 253 583 ширхэг хувьцаа авахыг зөвшөөрч шийдвэрлэсэн.